БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ МОНГОЛЫН СЭТГҮҮЛ
№28 (2), 2023.12


# БҮХ ТҮВШНИЙ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН БАГШИЙН АЖЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Оргил Цоморлиг[1], Ганбаатар Халиун[1], Усны-Эх Мягмаржав[1], Дорж Сарантуяа[1], Ганбаатар Түвшинжаргал[1]
[1] Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн

**Өгүүллийн мэдээлэл**

**Түүх:**
Хүлээн авсан: 2023.12.01
Засаж сайжруулсан: 2023.12.12
Хэвлэхийг зөвшөөрсөн: 2023.12.13

**Түлхүүр үг:**
боловсролын сургалтын байгууллага, ажлын сэтгэл ханамж, ажлын орчин нөхцөл, ажлын стресс, цалин хөлс

**Холбоо барих зохиогч:**
О.Цоморлиг
Email: tsomorlig@mier.mn

**Хураангуй**

Улс орнууд багшийг дэмжин урамшуулахын тулд ажлын таатай нөхцөл, мэргэжил дээшлүүлэх боломжоор хангах бодлогуудыг хэрэгжүүлж байна. Учир нь тэдгээр нөхцөл, боломж нь багш ажилдаа сэтгэл ханамжтай ажиллахад чухал ач холбогдолтой юм. Цаашилбал, багшийн ажлын сэтгэл ханамж нь түүнийг мэргэжлээрээ тогтвортой, гүйцэтгэл сайтай ажиллахад чухал нөлөөтэй. Энэхүү судалгаагаар бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын багшийн ажлын сэтгэл ханамж, түүний ялгаатай байдлыг тодорхойлохыг зорьсон. Судалгааны мэдээллийг боловсролын салбарын цахим платформыг (www.esis.edu.mn) ашиглан цуглуулав. Судалгаанд бүх түвшний сургалтын байгууллагын 10,429 багш хамрагдсан бөгөөд цулуулсан мэдээлэлд MS Excel болон SPSS (Statistical Package for the Social Sciences) программыг ашиглан боловсруулалт хийлээ. Судалгааны үр дүн нь сургалтын байгууллага хооронд багшийн ажлын сэтгэл ханамж нь статистик ач холбогдол бүхий ялгаатай болохыг харуулсан.

**Article Info**

## A STUDY ON TEACHERS' JOB SATISFACTION IN EDUCATIONAL INSTITUTIONS OF ALL LEVELS

**Authors:**
Tsomorlig, O[1]., Khaliun, G[1]., Myagmarjav, U[1]., Sarantuya, D[1]., Tuvshinjargal, G[1]

[1]Mongolian National Institute for Educational Research

**Article history:**
Received: Dec 1, 2023
Revised: Dec 12, 2023
Accepted: Dec 13, 2023

**Keywords:**
educational institutions, job satisfaction, working conditions, stress, salary

**Abstract:**
Many countries are implementing policies that provide favourable working conditions and professional development opportunities to encourage teachers. Those conditions and opportunities are essential for teachers to be satisfied with their work. Furthermore, teachers' job satisfaction has an important effect on their professional stability and high performance. This study aims to determine the extent of teachers' job satisfaction at all levels of educational institutions and whether there are differences between educational institutions. The data were collected through the online platform (www.esis.edu.mn) of the education sector. The 10,429 teachers (including university professors) of all levels of educational institutions participated in the survey. In addition, the data were processed using MS Excel and SPSS (Statistical Package for the Social Sciences) programs. As a result of this study, there was a statistically significant difference in teachers' job satisfaction between educational institutions.

https://journal.mnier.mn/
ISSN 2959-9164
DOI: https://doi.org/10.56380/v28.2.3



## УДИРТГАЛ

Боловсролын чанарыг сайжруулах нь улс орны хөгжилд онцгой хувь нэмэр оруулахыг онцлон, дэлхийн улс орнууд 2030 он гэхэд “Чанартай боловсрол” Тогтвортой хөгжлийн зорилго 4-д хүрэхэд чиглэсэн багшийн үүрэг, оролцооны талаарх бодлогод илүүтэй анхаарч байна. Тухайлбал, сайн багшийг бэлтгэхийн тулд сурлагын өндөр амжилттай, авьяаслаг элсэгчдийг багш мэргэжилд татан элсүүлж, тэднийг чанартай хөтөлбөрөөр сургаж бэлтгэн ажилд авах, улмаар багш мэргэжлээр тогтвортой, амжилттай ажиллахад нь дэмжих ажлын байрны таатай нөхцөл, мэргэжил дээшлүүлэх боломжоор хангахыг бодлогоор дэмжих нь чухал (Akiba, 2007; Akiba & LeTendre, 2017; UNESCO, Teacher Policy Development Guide, 2019) болохыг тэмдэглэжээ. Эндээс үзвэл сайн багшийг бий болгох бодлого нь шинээр багш мэргэжилтэн бэлтгэхээс эхэлсэн бүхэл бүтэн тогтолцоо байна. Өнөөгийн нөхцөлд мэргэжлээрээ ажиллаж буй багш нарын мэргэжлийн хөгжлийг дэмжих, ажлын байрны таатай нөхцөлөөр хангах нь чухал байна. Түүнчлэн багшийн ажлын байран дахь сэтгэл ханамжаар тэдний ажлын гүйцэтгэл, чанар болон ажлын байрандаа тогтвортой ажиллах эсэх нь тодорхойлогддог (OECD, 2009; Д.Түмэнбаяр, 2021). Ялангуяа багш нар мэргэжлээрээ тогтвортой ажиллахгүй байгаа шалтгаан нь ажлын сэтгэл ханамжтай шууд хамааралтай болохыг судлаачид онцолжээ (Forde & McMahon, 2019).

Монгол Улсын хувьд дэлхийн улс орнуудын чиг хандлагад нийцүүлэн багшид чиглэсэн бодлого, хууль тогтоомжийг шинээр батлах зэргээр эрх зүйн орчныг сайжруулан хэрэгжүүлж байна. Тухайлбал, Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль (2018) болон “Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөнд (2021) багш бэлтгэх, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжил, багшийн ажлын нөхцөл, цалин хөлстэй холбоотой зохицуулалтыг тусгасан байдаг. Хэдийгээр багшийг дэмжсэн эрх зүйн баримт бичгүүд батлагдан хэрэгжиж байгаа ч өнөөдрийн байдлаар багш хомсдолтой байгаагаас гадна багш мэргэжлээр төгсөгчид мэргэжлээрээ ажиллахгүй байна (БХ, 2019). Иймд одоогийн нөхцөлд багш ажлын байрандаа хэр сэтгэл ханамжтай байгааг судлах шаардлагатай байна.

## СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ

Сэдвийн судлагдсан байдлын хүрээнд олон улсын болон манай улсад хийгдсэн судалгааны үр дүн, судлаачдын ажлын сэтгэл ханамжийн талаарх тодорхойлолтыг авч үзлээ.

- Но, Холленбек, Герхарт, Райт нарын тодорхойлсноор “Ажлын сэтгэл ханамж гэдэг нь хувь хүн тухайн ажлыг гүйцэтгэснээр үнэт зүйлс, үнэлэмждээ хүрэх таатай мэдрэмж эсвэл үнэт зүйлс, үнэлэмждээ хүрэх боломж гэсэн ойлголтын үр дүнд бий болдог таатай мэдрэмж” (Noe, Hollenbeck, Gerhart, & Wright, 1996, p. 235) гэжээ.
- Ажлын сэтгэл ханамжид багшийн авч буй цалин хөлс, мэргэжлээрээ хөгжих боломж, ажлын нөхцөл, ачаалал, багшийн хувь нэмрийг хүлээн зөвшөөрч, үнэлдэг байдал зэрэг хүчин зүйлс нөлөөлдөг байна (Forde & McMahon, 2019).
- Багшийн нас, хүйс, ажилласан жил, орлогын хэмжээ (Hasanzadeh & Gholami, 2023), карьер, мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаа, сургуулийн захирлын хүйс, ажлын туршлага болон сургуулийн байршил, төрөл (Özkan & Akgenç, 2023) зэргээс хамааран багшийн ажлын сэтгэл ханамж харилцан адилгүй байна.
- Монгол улсад хийгдсэн “ЕБС-ийн багшийн ажлын сэтгэл ханамжийн судалгаа”-аар ЕБС-ийн багш нарын мэргэжлийн болон ажлын орчны сэтгэл ханамж өндөр байсан бөгөөд үүнд багшийн хүйс, мэргэжлийн зэрэг, багш-сурагчийн харилцаа болон хамтран ажиллагсдын хамтын ажиллагаа эерэг хамааралтай байжээ (Г.Өлзийсайхан, 2017).
- “Багшийн ажлын байран дахь сэтгэл ханамжийн судалгаа”-аар цэцэрлэг болон ЕБС-ийн багшийн насны бүлгээс хамаарч ажлын байран дахь сэтгэл ханамж ялгаатай байгааг тодорхойлсон байна (Д.Түмэнбаяр, А.Амарзаяа зэрэг судлаачид (2021)).

## СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Багшийн ажлын сэтгэл ханамжийг судалсан гадаад болон Монгол улсын тодорхой хэмжээний судалгаанууд байгаа хэдий ч боловсролын аль нэг түвшний багшид (жишээ нь: ЕБС-ийн багш) төвлөрсөн байна. Мөн түүнчлэн боловсролын түвшин бүрийн багшийн ажлын сэтгэл ханамж хооронд ялгаа байгаа эсэх нь тодорхойгүй байна.
Иймд энэхүү судалгааны зорилго нь бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын багшийн ажлын сэтгэл ханамж, түүний ялгаатай байдлыг тодорхойлоход оршино. Судалгааны зорилгод хүрэхийн тулд ажлын стресс ба эрүүл мэнд; ажлын байрны дарамт; мэргэжлийн болон ажлын сэтгэл ханамж; ажлын гүйцэтгэл болон мэргэжлийн ур чадвар, цалин хөлс ба ажлын орчин нөхцөл, сургалтын байгууллага, хамт олонтой холбоотой сэтгэл ханамжийг илрүүлэхийг зорилоо

## СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгааны зорилгод хүрэхийн тулд тоон судалгааны аргыг ашиглан гүйцэтгэлээ.

*Судалгааны хэрэгсэл боловсруулалт*

ЭЗХАХБ-аас зохион байгуулдаг “Багшлахуй, суралцахуйн олон улсын судалгаа” (TALIS)-ны нэг судлах зүйл нь ерөнхий боловсролын сургуулийн багш болон сургуулийн удирдах ажилтны ажлын сэтгэл ханамж байдаг бөгөөд олон улс орнуудын судалгааны үр дүнг харьцуулан тайлагнадаг. Энэхүү олон улсын судалгаа нь ажлын сэтгэл ханамжийн судалгааны чиглэлийн асуулгуудыг ашиглан багш, сургуулийн удирдах ажилтны ажлын сэтгэл ханамж, стрессийн түвшин, түүнд нөлөөлөх хүчин зүйлс, сургалтын болон ажлын орчинтой холбоотой сэтгэл ханамжийг үнэлсэн байдаг.
Судалгааны багаас асуулгыг өмнө нь хийгдсэн судалгаа болон ЭЗХАХБ-ын “Багшлахуй, суралцахуйн олон улсын судалгаа” (TALIS)-ны 2018 оны багш, удирдах ажилтны сэтгэл ханамжийн судалгааны асуулгад үндэслэн боловсруулав.
Асуулга судалгааг боловсруулахдаа бүх түвшний сургалтын байгууллагын багш нарын ажлын онцлогоос хамаарч нийтлэг болон ялгаатай асуултуудыг тусгасан. Асуулга судалгааны эхний хэсэгт ерөнхий мэдээлэл (нас, хүйс, боловсролын зэрэг, мэргэжлийн зэрэг, багшаар ажилласан жил, сургуулийн байршил, гэх мэт), хоёр дахь хэсэгт багшийн өөрийн сэтгэл ханамжийн үнэлгээг Лайкертийн шкалаар хэмжигдэхээр боловсруулсан.

*Судалгааны мэдээлэл цуглуулалт, боловсруулалт*

Судалгааны мэдээллийг Боловсролын мэдээллийн технологийн төвийн асуулгын платформ ашиглан Монгол улсын хэмжээнд онлайнаар цуглуулав. Цуглуулсан мэдээлэлд MS Excel болон SPSS 26.0 программыг ашиглан боловсруулалт хийлээ. Бүх түвшний сургалтын байгууллагын багшийн ажлын сэтгэл ханамжийг тодорхойлохын тулд судалгааны мэдээлэлд дескриптив статистик шинжилгээ хийж, үр дүнд боловсруулалт хийсэн. Ингэхдээ цуглуулсан мэдээлэл нь ординал хувьсагч тул хувьчлах болон Моод *(Mo)*-г тооцсон. Харин түвшин хооронд ялгаа байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор ординал өгөгдөлд нийцүүлэн Крускал-Уоллис (Kruskal-Wallis) тест хийв.

## СУДАЛГААНЫ ҮР ДҮН

*Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл*

Боловсрол, шинжлэх ухааны салбарын 2022-2023 оны статистикийн мэдээлэлд дурдсанаар Монгол улсын хэмжээнд сургуулийн өмнөх боловсрол (СӨБ)-ын сургалтын байгууллагад 9450; ерөнхий боловсрол (ЕБ)-ын сургалтын байгууллагад 36118; мэргэжлийн болон техникийн боловсрол (МБТБ)-ын сургалтын

https://journal.mnier.mn/
ISSN 2959-9164
DOI: https://doi.org/10.56380/v28.2.3


байгууллагад 2252; дээд боловсролын сургалтын байгууллагад 5169 үндсэн багш тус тус ажиллаж байна.

Энэхүү судалгаанд СӨБ-ын сургалтын байгууллагын багш нарын 11.5 хувь буюу 1091; ЕБ-ын сургалтын байгууллагын багш нарын 20 хувь буюу 7242; МБТБ-ын сургалтын байгууллагын багш нарын 42 хувь буюу 947; ДБ-ын сургалтын байгууллагын багш нарын 22.9 хувь 1149 оролцогч хамрагджээ. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээллийг Хүснэгт 1-д үзүүлэв.

*Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл (n=10429)*

| **Ерөнхий мэдээлэл** | | **Цэцэрлэгийн багш (n=1091)** | **ЕБС-ийн багш (n=7242)** | **МБТБ багш (n=947)** | **ДБСБ-ын багш (n=1149)** |
|---|---|---|---|---|---|
| Нас | 25 хүртэлх | 5.4 % | 11.8% | 7.7% | 7.7% |
| | 26-30 | 14.8% | 16.2% | 14.5% | 12.8% |
| | 31-35 | 17.7% | 20.5% | 18.0% | 18.5% |
| | 36-40 | 16.9% | 15.9% | 18.7% | 17.3% |
| | 41-45 | 16.0% | 14.6% | 17.3% | 17.2% |
| | 46-50 | 15.7% | 10.2% | 10.2% | 12.8% |
| | 51-55 | 12.7% | 6.6% | 10.0% | 9.3% |
| | 56 болон түүнээс дээш | 1.0% | 4.0% | 3.6% | 4.5% |
| Хүйс | Эрэгтэй | 0.6% | 14.3% | 28.2% | 31.9% |
| | Эмэгтэй | 99.4% | 85.7% | 71.8% | 68.2% |
| Боловсролын түвшин | Дипломын | 5.6% | 5.6% | 6.3% | 3.9% |
| | Бакалавр | 77.4% | 65.8% | 57.4% | 43.0% |
| | Магистр | 17.0% | 28.3% | 36.0% | 40.7% |
| | Доктор | | 0.2% | 0.3% | 12.4% |
| Багшаар ажилласан нийт жил | Анхны жил | 10.2% | 6.7% | 9.2% | 7.8% |
| | 2-5 жил | 22.5% | 22.5% | 20.7% | 18.5% |
| | 6-10 жил | 26.6% | 19.7% | 18.9% | 19.0% |
| | 11-15 жил | 12.6% | 16.4% | 19.1% | 17.2% |
| | 16-20 жил | 10.0% | 13.9% | 13.2% | 15.3% |
| | 21-25 жил | 8.1% | 9.9% | 9.3% | 11.8% |
| | 26 -аас дээш | 10.1% | 11.0% | 9.7% | 10.3% |
| Байршил | Нийслэл | 47.7% | 43.7% | 31.9% | 88.9% |
| | Аймгийн төв | 24.6% | 24.8% | 58.4% | 9.8% |
| | Сум | 25.0% | 29.4% | 9.3% | 0.9% |
| | Баг | 2.8% | 2.0% | 0.4% | 0.5% |
| Өмчийн хэлбэр | Төрийн | 98.9% | 97.9% | 88.6% | 58.5% |
| | Төрийн бус | 1.1% | 2.1% | 11.4% | 41.5% |

*Дескриптив статистик шинжилгээний үр дүн*

Энэ хэсэгт хамгийн их давтагдсан хариулт болох Моод утгаар бүх түвшний сургалтын байгууллагын багшийн ажлын сэтгэл ханамжийн үр дүнг тайлбарлах болно.

Хүснэгт 2 болон 3-д харуулсан ажлын стресс, эрүүл мэндтэй холбоотой сэтгэл ханамжийн үр дүнгээс үзвэл бүх түвшний сургалтын байгууллагын багш нарын дунд ажилдаа “заримдаа” стрессддэг (*Mo=3*), цэцэрлэгийн багшаас бусад түвшний багш нарын хувьд ажил нь “заримдаа” хувийн амьдралдаа цаг зарцуулах боломж олгодоггүй (*Mo=3*) гэдэгт хамгийн их хариулт өгчээ. Харин цэцэрлэгийн багшийн тухайд “ихэнхдээ” хувийн амьдралдаа цаг зарцуулах боломжгүй (*Mo=4*) байдаг гэжээ. Багш нар ажлаа сэтгэл зүйд нь хэр зэрэг сөргөөр нөлөөдөг тал дээр харилцан адилгүй хариулт өгсөн байна. Тухайлбал, цэцэрлэгийн багш “огт үгүй” (*Mo=1*), ЕБ-ын болон МБТБ-ын сургалтын байгууллагын багш “ховор тохиолдолд” (*Mo=2*), ДБ-ын сургалтын байгууллагын багш “заримдаа” (*Mo=3*) гэсэн хариулт илүү их давтамжтай байна. Харин тэдний ажил эрүүл мэндэд (биеийн) нь цэцэрлэг болон ЕБС-ийн багшийн тухайд “заримдаа” (*Mo=3*), МБТБ болон ДБ-ын сургалтын байгууллагын багш нар “ховор тохиолдолд” (*Mo=2*) сөргөөр нөлөөлдөг гэжээ.

*Хүснэгт 2. Цэцэрлэг болон ЕБС-ийн багшийн ажлын стресс ба эрүүл мэндтэй холбоотой сэтгэл ханамжийн үр дүн, хувиар*

| № | Ажлын стресс ба эрүүл мэндтэй холбоотой сэтгэл ханамж | **Цэцэрлэгийн багш (*n=1091*)** | | | | | **ЕБС-ийн багш (*n=7242*)** | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | *1 (%)* | *2 (%)* | *3 (%)* | *4 (%)* | *Моод (Mo)* | *1 (%)* | *2 (%)* | *3 (%)* | *4 (%)* | *Моод (Mo)* |
| 1.1 | Би ажилдаа стрессддэг. | 13.9 | 31.1 | 42.4 | 12.6 | **3** | 8.0 | 28.0 | 46.9 | 17.1 | **3** |
| 1.2 | Миний ажил надад хувийн амьдралдаа цаг зарцуулах боломж олгодоггүй. | 11.8 | 18.1 | 34.8 | 35.3 | **4** | 8.2 | 23.6 | 41.0 | 27.3 | **3** |
| 1.3 | Миний ажил сэтгэл зүйд минь сөргөөр нөлөөлдөг. | 39.5 | 27.0 | 26.3 | 7.1 | **1** | 24.1 | 34.3 | 32.2 | 9.4 | **2** |
| 1.4 | Миний ажил эрүүл мэндэд (биеийн) минь сөргөөр нөлөөлдөг. | 24.3 | 24.7 | 31.7 | 19.3 | **3** | 16.2 | 29.9 | 37.9 | 15.9 | **3** |

*Тэмдэглэл.* Огт үгүй – 1, ховор тохиолдолд – 2, заримдаа – 3, Ихэнхдээ – 4

*Хүснэгт 3. МБТБ болон ДБ-ын сургалтын байгууллагын багшийн ажлын стресс ба эрүүл мэндтэй холбоотой сэтгэл ханамжийн үр дүн, хувиар*

| № | Ажлын стресс ба эрүүл мэндтэй холбоотой сэтгэл ханамж | **МБТБ-ын сургалтын байгууллагын багш (*n=947*)** | | | | | **ДБ-ын сургалтын байгууллагын багш (*n=1149*)** | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | *1 (%)* | *2 (%)* | *3 (%)* | *4 (%)* | *Моод (Mo)* | *1 (%)* | *2 (%)* | *3 (%)* | *4 (%)* | *Моод (Mo)* |
| 1.1 | Би ажилдаа стрессддэг. | 7.8 | 27.0 | 48.4 | 16.8 | **3** | 11.7 | 30.2 | 41.3 | 16.7 | **3** |
| 1.2 | Миний ажил надад хувийн амьдралдаа цаг | 9.4 | 29.4 | 38.4 | 22.8 | **3** | 13.8 | 27.0 | 38.6 | 20.7 | **3** |

https://journal.mnier.mn/
ISSN 2959-9164
DOI: https://doi.org/10.56380/v28.2.3

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зарцуулах боломж олгодоггүй. | | | | | | | | | | |
| 1.3 | Миний ажил сэтгэл зүйд минь сөргөөр нөлөөлдөг. | 30.7 | 36.1 | 25.4 | 7.7 | **2** | 27.5 | 29.0 | 31.9 | 11.7 | **3** |
| 1.4 | Миний ажил эрүүл мэндэд (биеийн) минь сөргөөр нөлөөлдөг. | 26.1 | 34.3 | 28.0 | 11.6 | **2** | 26.8 | 33.2 | 29.2 | 10.8 | **2** |

*Тэмдэглэл.* Огт үгүй – 1, ховор тохиолдолд – 2, заримдаа – 3, Ихэнхдээ – 4

Хүснэгт 4 болон 5-д судалгаанд оролцогчдод ажлын стресс үүсгэдэг хүчин зүйлс, эх үүсвэрийг талаарх үр дүнг нэгтгэн харууллаа. Үндсэн ажилтай холбоотой ачаалал үүсгэж буй хүчин зүйлс болох хичээл, сургалтын үйл ажиллагааны бэлтгэлд цэцэрлэг, ЕБС-ийн багш нар “заримдаа” (*Mo=3*), МБТБ-ын сургалтын байгууллагын багш “ховор тохиолдолд” (*Mo=2*) цаг их зарцуулдаг гэжээ. Харин долоо хоногт заах хичээлийн цаг их байдаг нь ЕБС-ийн багш нарын хувьд “огт” (*Mo=1*) , МБТБ болон ДБ-ын сургалтын байгууллагын багш нарын тухайд “ховор тохиолдолд” (*Mo=2*) бухимдуулдаг гэсэн хариулт илүү их давтамжтай байна. Цэцэрлэгийн багшийн хувьд долоо хоногт ажиллах цаг их байдаг нь “заримдаа” (*Mo=3*) бухимдлыг нь төрүүлдэг гэжээ. Мөн бүлэг дүүргэлт их байдаг нь цэцэрлэг, ЕБС-ийн багш нарын дунд бухимдал үүсгэдэггүй гэсэн хариулт илүү байна.

Харин үндсэн ажлаас гадна гүйцэтгэж буй ажил болох байгууллагын захиргааны ажилд оролцох нь бүх түвшний сургалтын байгууллагын багш нарт “заримдаа” (*Mo=3*) бухимдал үүсгэдэг бол эзгүй байгаа багшийн ажлыг давхар гүйцэтгэх нь ЕБС-ийн багшаас бусад багш нарын дунд “огт” хүндрэл үүсгэдэггүй гэжээ. ЕБС-ийн багшийн хувьд энэ нь “ховор тохиолдолд” л (*Mo=2*) бухимдал үүсгэдэг болохоо илэрхийлжээ.

Суралцагчийн зан үйл болон оролцогч талуудын өмнө хүлээх хариуцлагатай холбоотой сэтгэл ханамж багш нарын дунд харилцан адилгүй байна. Тухайлбал, цэцэрлэгийн багшийн дунд “Суралцагчийн сурлагын ахиц, амжилтад хариуцлага хүлээх нь надад хэцүү санагддаг”, “Ялгаатай хэрэгцээ шаардлагатай суралцагчдад зориулж багшлах үйл ажиллагаандаа тохируулга хийх нь хүндрэл учруулдаг”, “Эцэг эх, асран хамгаалагчийн харилцаа, хандлага стрессдүүлдэг” гэдэгт “огт үгүй” (*Mo=1*) гэсэн хариулт давтамж өндөртэй байна. Гэтэл ЕБ, МБТБ болон ДБ-ын сургалтын байгууллагын багш нарын хувьд “ховор тохиолдолд” (*Mo=2*), “заримдаа” (*Mo=3*) эдгээр хүчин зүйлс бухимдал үүсгэдэг гэжээ. Харин дээд шатны байгууллага бодлого, шийдвэрээ богино хугацаанд өөрчилдөг нь багш нарыг “заримдаа” бухимдуулдаг гэсэн хариулт илүү давтамжтай байна. Гэхдээ ДБ-ын сургалтын байгууллагын багш нарын дунд “ихэнхдээ” (*Mo=4*) гэсэн хариулт мөн давтамж өндөртэй байв.

Бүх түвшний сургалтын байгууллагын багш нарын ихэнх нь ажлын байрны дарамтгүй ажилладаг болохоо илэрхийлсэн байна.

*Хүснэгт 4. Цэцэрлэг болон ЕБС-ийн багш нарт ажлын стресс үүсгэж буй шалтгаан, эх үүсвэр, хувиар*

| № | Ажлын стрессийн шалтгаан, эх үүсвэр | **Цэцэрлэгийн багш (*n=1091*)** | | | | | **ЕБС-ийн багш (*n=7242*)** | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | *1 (%)* | *2 (%)* | *3 (%)* | *4 (%)* | *Моод (Мо)* | *1 (%)* | *2 (%)* | *3 (%)* | *4 (%)* | *Моод (Мо)* |
| *Үндсэн ажилтай холбоотой ачаалал үүсгэж буй хүчин зүйлс* | | | | | | | | | | | |
| 2.1 | Хичээлийн бэлтгэлд цаг их зарцуулдаг нь намайг бухимдуулдаг./ Сургалт, үйл ажиллагаанд бэлтгэх цаг их зарцуулдаг нь намайг бухимдуулдаг* | 21.7 | 29.5 | 34.1 | 14.7 | **3** | 14.6 | 32.1 | 37.8 | 15.5 | **3** |
| 2.2 | Долоо хоногт заах хичээлийн цаг их байдаг нь намайг бухимдуулдаг./ Долоо хоногт ажиллах цаг их байдаг нь намайг бухимдуулдаг* | 24.2 | 27.6 | 32.2 | 16.0 | **3** | 37.9 | 32.8 | 22.2 | 7.1 | **1** |
| 2.3 | Бүлэг дүүргэлт их байдаг нь надад хүндрэлтэй байдаг. | 35.1 | 23.2 | 22.6 | 19.1 | **1** | 28.3 | 23.1 | 22.7 | 25.9 | **1** |
| *Үндсэн ажлаас гадуур гүйцэтгэж буй ажилтай холбоотой ажлын ачаалал үүсгэж буй хүчин зүйлс* | | | | | | | | | | | |
| 2.4 | Байгууллагын захиргааны ажил (маягт бөглөх, бичиг цаасны ажил г.м) - д их оролцох нь надад төвөгтэй байдаг. | 23.1 | 23.8 | 31.9 | 21.2 | **3** | 15.5 | 27.4 | 35.5 | 21.7 | **3** |
| 2.5 | Эзгүй байгаа багшийн ажлыг давхар гүйцэтгэх нь надад хүндрэлтэй байдаг. | 38.0 | 25.7 | 23.3 | 13.0 | **1** | 31.0 | 32.6 | 25.8 | 10.7 | **2** |
| *Суралцагчийн зан үйл болон оролцогч талуудын өмнө хүлээх үүрэг хариуцлагатай холбоотой сэтгэл ханамж* | | | | | | | | | | | |
| 2.6 | Суралцагчийн сурлагын ахиц, амжилтад хариуцлага хүлээх нь надад хэцүү санагддаг. | 42.9 | 26.3 | 22.6 | 8.2 | **1** | 19.8 | 30.8 | 34.0 | 15.3 | **3** |
| 2.7 | Суралцагчдын зүй бус харилцаа намайг бухимдуулдаг. | - | - | - | - | **-** | 15.1 | 29.8 | 34.2 | 20.9 | **3** |
| 2.8 | Ялгаатай хэрэгцээ шаардлагатай суралцагчдад зориулж багшлах үйл ажиллагаандаа | 33.7 | 30.1 | 25.3 | 10.9 | **1** | 21.2 | 35.9 | 32.1 | 10.7 | **2** |

https://journal.mnier.mn/
ISSN 2959-9164
DOI: https://doi.org/10.56380/v28.2.3

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тохируулга хийх нь хүндрэл учруулдаг. | | | | | | | | | | |
| 2.9 | Эцэг эх, асран хамгаалагчийн харилцаа, хандлага стрессдүүлдэг. | 34.8 | 29.0 | 27.6 | 8.6 | **1** | 17.1 | 32.7 | 33.8 | 16.4 | **3** |
| 2.10 | Дээд шатны байгууллага бодлого, шийдвэрээ богино хугацаанд өөрчилдөг нь намайг бухимдуулдаг. | 24.4 | 25.5 | 28.1 | 22.0 | **3** | 15.1 | 27.9 | 34.7 | 22.2 | **3** |
| *Ажлын байрны дарамттай холбоотой* | | | | | | | | | | | |
| 2.11 | Байгууллагын удирдлагын зүгээс ажлын байрны дарамт (сэтгэл зүйн болон биеийн) үзүүлдэг. | 60.0 | 17.4 | 14.2 | 7.5 | **1** | 51.9 | 26.7 | 16.0 | 5.4 | **1** |
| 2.12 | Хамт олны зүгээс ажлын байрны дарамт (сэтгэл зүйн болон биеийн) үзүүлдэг. | 68.5 | 17.5 | 10.4 | 3.6 | **1** | 56.8 | 26.3 | 13.5 | 3.4 | **1** |
| 2.13 | Удирдлагын тогтворгүй байдал нь миний ажилд хүндрэл учруулдаг. | 55.9 | 18.9 | 16.3 | 8.9 | **1** | 39.0 | 29.5 | 21.5 | 10.0 | **1** |

*Тэмдэглэл.* Огт үгүй – 1, ховор тохиолдолд – 2, заримдаа – 3, Ихэнхдээ – 4
* Цэцэрлэгийн багшийн асуулга
- тухайн түвшний багшийн асуулгад ороогүй тул мэдээлэл байхгүйг илтгэнэ

*Хүснэгт 5. МБТБ болон ДБ-ын сургалтын байгууллагын багш нарт ажлын стресс үүсгэж буй шалтгаан, эх үүсвэр, хувиар*

| **№** | **Ажлын стрессийн шалтгаан, эх үүсвэр** | **МБТБ-ын сургалтын байгууллагын багш (*n=947*)** | | | | | **ДБ-ын сургалтын байгууллагын багш (*n=1149*)** | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | *1 (%)* | *2 (%)* | *3 (%)* | *4 (%)* | *Моод (Мо)* | *1 (%)* | *2 (%)* | *3 (%)* | *4 (%)* | *Моод (Мо)* |
| *Үндсэн ажилтай холбоотой ачаалал үүсгэж буй хүчин зүйлс* | | | | | | | | | | | |
| 2.1 | Хичээлийн бэлтгэлд цаг их зарцуулдаг нь намайг бухимдуулдаг. | 18.5 | 36.5 | 32.4 | 12.6 | **2** | - | - | - | - | **-** |
| 2.2 | Долоо хоногт заах хичээлийн цаг их байдаг нь намайг бухимдуулдаг. | 31.8 | 33.5 | 25.6 | 9.2 | **2** | 28.9 | 29.4 | 28.9 | 12.8 | **2** |
| 2.3 | Бүлэг дүүргэлт их байдаг нь надад хүндрэлтэй байдаг. | - | - | - | - | **-** | - | - | - | - | **-** |
| *Үндсэн ажлаас гадуур гүйцэтгэж буй ажилтай холбоотой ажлын ачаалал үүсгэж буй хүчин зүйлс* | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.4 | Байгууллагын захиргааны ажил (маягт бөглөх, бичиг цаасны ажил г.м) - д их оролцох нь надад төвөгтэй байдаг. | 14.7 | 25.0 | 35.1 | 25.2 | **3** | 21.9 | 27.6 | 29.0 | 21.5 | **3** |
| 2.5 | Эзгүй байгаа багшийн ажлыг давхар гүйцэтгэх нь надад хүндрэлтэй байдаг. | 39.5 | 30.8 | 20.3 | 9.4 | **1** | 38.2 | 30.1 | 19.2 | 12.4 | **1** |
| *Суралцагчийн зан үйл болон оролцогч талуудын өмнө хүлээх үүрэг хариуцлагатай холбоотой сэтгэл ханамж* | | | | | | | | | | | |
| 2.6 | Суралцагчийн сурлагын ахиц, амжилтад хариуцлага хүлээх нь надад хэцүү санагддаг. | 23.5 | 34.3 | 28.4 | 13.7 | **2** | - | - | - | - | **-** |
| 2.7 | Суралцагчдын зүй бус харилцаа намайг бухимдуулдаг. | 12.8 | 29.0 | 35.8 | 22.4 | **3** | 31.2 | 36.4 | 24.9 | 7.5 | **2** |
| 2.8 | Ялгаатай хэрэгцээ шаардлагатай суралцагчдад зориулж багшлах үйл ажиллагаан-даа тохируулга хийх нь хүндрэл учруулдаг. | 24.0 | 40.7 | 27.1 | 8.2 | **2** | 32.8 | 34.6 | 23.8 | 8.8 | **2** |
| 2.9 | Эцэг эх, асран хамгаалагчийн харилцаа, хандлага стрессдүүлдэг. | 26.0 | 35.9 | 27.9 | 10.2 | **2** | - | - | - | - | **-** |
| 2.10 | Дээд шатны байгууллага бодлого, шийдвэрээ богино хугацаанд өөрчилдөг нь намайг бухимдуулдаг. | 12.5 | 24.6 | 35.4 | 27.6 | **3** | 13.4 | 23.9 | 31.3 | 31.3 | **3a** |
| *Ажлын байрны дарамттай холбоотой* | | | | | | | | | | | |
| 2.11 | Байгууллагын удирдлагын зүгээс ажлын байрны дарамт (сэтгэл зүйн болон биеийн) үзүүлдэг. | 41.7 | 29.6 | 19.1 | 9.6 | **1** | 42.6 | 28.2 | 17.8 | 11.4 | **1** |
| 2.12 | Хамт олны зүгээс ажлын байрны дарамт (сэтгэл зүйн болон биеийн) үзүүлдэг. | 51.3 | 29.4 | 15.7 | 3.6 | **1** | 50.4 | 28.1 | 15.0 | 6.5 | **1** |
| 2.13 | Удирдлагын тогтворгүй байдал нь миний ажилд хүндрэл учруулдаг. | 28.9 | 28.5 | 23.2 | 19.3 | **1** | 29.3 | 27.9 | 21.9 | 20.9 | **1** |

*Тэмдэглэл.* Огт үгүй – 1, ховор тохиолдолд – 2, заримдаа – 3, Ихэнхдээ – 4
- тухайн түвшний багшийн асуулгад ороогүй тул мэдээлэл байхгүйг илтгэнэ
а – 1-ээс илүү моод байгааг илтгэнэ

https://journal.mnier.mn/
ISSN 2959-9164
DOI: https://doi.org/10.56380/v28.2.3



Хүснэгт 6 ба Хүснэгт 7-д судалгаанд оролцогчдын мэргэжлийн болон ажлын сэтгэл ханамжийн үр дүнг харуулав. Багш мэргэжил давуу тал ихтэй гэдэгтэй СӨБ болон ДБ-ын сургалтын байгууллагын багш нарын дунд “бүрэн санал нийлж байна” (*Mo=4*), ЕБС болон МБТБ-ын сургалтын байгууллагын багш нарын дунд “санал нийлж байна” (*Mo=3*) гэсэн хариултууд хамгийн их давталттай байна. Сонирхолтой нь СӨБ, ЕБ болон МБТБ-ын сургалтын байгууллагын багш нар хэрэв дахин мэргэжлээ сонгох бол багш мэргэжлийг сонгохгүй гэсэн хариулт давамгайлсан байна. Гэхдээ одоогийн нөхцөлд багш мэргэжлийг сонгосондоо сэтгэл дундуур байна гэдэгтэй санал нийлэхгүй байгаагаа илэрхийлжээ (*Mo=1* болон *Mo=2*). ЕБС-ийн багш нараас бусад нь “Миний бодлоор багшийн ажил нийгэмд нэр хүндтэй” гэдэгтэй санал нийлсэн бол ЕБС-ын багш нарын дунд “санал нийлэхгүй байна” гэсэн хариулт илүү давталттай байна. Бүх түвшний сургалтын байгууллагын багш нарын дунд “Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл нь багшийн нэр хүндийг өсгөхөд нөлөөлдөг” гэдэгтэй санал нийлээгүй байна.

Бүх түвшний сургалтын байгууллагын багш нарын ажлын сэтгэл ханамж өндөр байна. Тухайлбал, багш нарын дунд боломж олдвол өөр сургалтын байгууллага руу шилжин ажиллахтай санал нийлэх эсэхийг тодруулахад тэд “огт санал нийлэхгүй” гэсэн хариулт давталт өндөртэй байв. Цэцэрлэгийн багш нар одоо ажиллаж буй байгууллагадаа ажиллахдаа дуртай байдаг бөгөөд бусад багш нарт өөрийн байгууллагадаа ирж ажиллахыг санал болгох тал дээр бүрэн санал нийлжээ (*Mo=4*).

Цаашилбал, цэцэрлэг, ЕБ, МБТБ-ын сургалтын байгууллагын багш нар ихэнх нь ажлын гүйцэтгэл болон мэргэжлийн ур чадвартаа сэтгэл хангалуун (*Mo=3* болон *Mo=4*) боловч ЕБС-ийн багш нар багшийн ажлын гүйцэтгэлийн хөндлөнгийн үнэлгээнд сэтгэл хангалуун бус байна (*Mo=2*).

*Хүснэгт 6. Цэцэрлэг болон ЕБС-ийн багшийн мэргэжлийн болон ажлын сэтгэл ханамж, хувиар*

| № | Мэргэжлийн болон ажлын сэтгэл ханамж | Цэцэрлэгийн багш (*n=1091*) | | | | | ЕБС-ийн багш (*n=7242*) | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1 (%) | 2 (%) | 3 (%) | 4 (%) | *Моод (Мо)* | 1 (%) | 2 (%) | 3 (%) | 4 (%) | *Моод (Мо)* |
| *Мэргэжлийн сэтгэл ханамж* | | | | | | | | | | | |
| 3.1 | Багш мэргэжил давуу тал ихтэй гэж би боддог. | 6.5 | 16.0 | 33.4 | 44.1 | **4** | 6.4 | 20.1 | 42.3 | 31.3 | **3** |
| 3.2 | Хэрэв мэргэжил дахин сонгох болбол би багш мэргэжлийг сонгоно. | 30.6 | 19.7 | 23.7 | 25.9 | **1** | 32.2 | 27.6 | 24.6 | 15.6 | **1** |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3 | Би багш мэргэжлийг сонгосондоо сэтгэл дундуур байдаг. | 51.1 | 22.3 | 16.4 | 10.2 | **1** | 32.0 | 32.7 | 25.9 | 9.4 | **2** |
| 3.4 | Би өөр мэргэжил сонгосон бол илүү сэтгэл хангалуун байх байсан. | 42.3 | 22.7 | 20.7 | 14.4 | **1** | 24.3 | 30.7 | 29.1 | 15.9 | **2** |
| 3.5 | Миний бодлоор багшийн ажил нь нийгэмд нэр хүндтэй. | 20.5 | 20.8 | 29.1 | 29.6 | **4** | 27.7 | 29.1 | 27.5 | 15.6 | **2** |
| 3.6 | Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл нь багшийн нэр хүндийг өсгөхөд нөлөөлдөг. | 41.7 | 28.0 | 22.5 | 7.8 | **1** | 42.2 | 33.0 | 19.5 | 5.2 | **1** |
| *Ажлын сэтгэл ханамж* | | | | | | | | | | | |
| 3.7 | Би боломж олдвол өөр сургалтын байгууллага руу шилжин ажиллах хүсэлтэй. | 43.7 | 20.8 | 19.8 | 15.7 | **1** | 31.4 | 27.9 | 27.0 | 13.7 | **1** |
| 3.8 | Би энэ байгууллагад ажиллахдаа дуртай байдаг. | 7.6 | 11.5 | 31.1 | 49.9 | **4** | 6.7 | 17.3 | 41.0 | 35.0 | **3** |
| 3.9 | Би багш нарт манай байгууллагад ирж ажиллахыг санал болгоно. | 16.0 | 19.9 | 30.9 | 33.2 | **4** | 12.8 | 24.5 | 39.8 | 22.9 | **3** |
| 3.10 | Би ажилдаа сэтгэл ханамжтай байдаг. | 4.6 | 13.1 | 34.9 | 47.4 | **4** | 5.3 | 20.1 | 46.5 | 28.0 | **3** |
| *Ажлын гүйцэтгэл болон мэргэжлийн ур чадвартай холбоотой сэтгэл ханамж* | | | | | | | | | | | |
| 3.11 | Би өөрийн ажлын гүйцэтгэлдээ сэтгэл хангалуун байдаг. | 2.9 | 8.5 | 37.6 | 51.0 | **4** | 3.0 | 12.6 | 50.2 | 34.1 | **3** |
| 3.12 | Багшийн ажлын гүйцэтгэлийн хөндлөнгийн үнэлгээнд сэтгэл хангалуун байдаг. | 13.3 | 17.7 | 41.2 | 27.9 | **3** | 21.4 | 34.0 | 33.9 | 10.7 | **2** |
| 3.13 | Би мэргэжлийн мэдлэг, ур чадвартаа сэтгэл хангалуун байдаг. | 3.6 | 10.4 | 36.6 | 49.4 | **4** | 3.3 | 13.1 | 47.9 | 35.7 | **3** |
| 3.14 | Би мэдээллийн технологийн чадвартаа сэтгэл хангалуун байдаг. | 3.6 | 11.9 | 43.9 | 40.6 | **3** | 3.3 | 17.7 | 51.6 | 27.4 | **3** |

*Тэмдэглэл.* Огт санал нийлэхгүй байна. - 1; Санал нийлэхгүй байна. - 2; Санал нийлж байна. - 3; Бүрэн санал нийлж байна. - 4

*Хүснэгт 7. МБТБ болон ДБ-ын сургалтын байгууллагын багш нарт ажлын стресс үүсгэж буй шалтгаан, эх үүсвэр, хувиар*

https://journal.mnier.mn/
ISSN 2959-9164
DOI: https://doi.org/10.56380/v28.2.3

| № | Мэргэжлийн болон ажлын сэтгэл ханамж | МБТБ-ын сургалтын байгууллагын багш (*n=947*) | | | | | ДБ-ын сургалтын байгууллагын багш (*n=1149*) | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1 (%) | 2 (%) | 3 (%) | 4 (%) | *Моод (Мо)* | 1 (%) | 2 (%) | 3 (%) | 4 (%) | *Моод (Мо)* |
| *Мэргэжлийн сэтгэл ханамж* | | | | | | | | | | | |
| 3.1 | Багш мэргэжил давуу тал ихтэй гэж би боддог. | 7.3 | 20.5 | 40.8 | 31.5 | **3** | 3.3 | 9.2 | 33.9 | 53.6 | **4** |
| 3.2 | Хэрэв мэргэжил дахин сонгох болбол би багш мэргэжлийг сонгоно. | 31.3 | 26.2 | 26.8 | 15.7 | **1** | - | - | - | - | **-** |
| 3.3 | Би багш мэргэжлийг сонгосондоо сэтгэл дундуур байдаг. | 37.6 | 31.9 | 20.2 | 10.3 | **1** | - | - | - | - | **-** |
| 3.4 | Би өөр мэргэжил сонгосон бол илүү сэтгэл хангалуун байх байсан. | 28.1 | 34.0 | 22.4 | 15.5 | **2** | - | - | - | - | **-** |
| 3.5 | Миний бодлоор багшийн ажил нь нийгэмд нэр хүндтэй. | 23.8 | 25.6 | 31.3 | 19.4 | **3** | 11.8 | 19.8 | 34.5 | 33.9 | **3** |
| 3.6 | Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл нь багшийн нэр хүндийг өсгөхөд нөлөөлдөг. | 41.7 | 33.6 | 19.2 | 5.5 | **1** | 34.8 | 35.9 | 23.2 | 6.0 | **2** |
| *Ажлын сэтгэл ханамж* | | | | | | | | | | | |
| 3.7 | Би боломж олдвол өөр сургалтын байгууллага руу шилжин ажиллах хүсэлтэй. | 35.8 | 25.7 | 22.8 | 15.7 | **1** | 39.1 | 29.1 | 20.5 | 11.4 | **1** |
| 3.8 | Би энэ байгууллагад ажиллахдаа дуртай байдаг. | 7.0 | 16.6 | 42.2 | 34.2 | **3** | 3.6 | 13.6 | 41.2 | 41.7 | **4** |
| 3.9 | Би багш нарт манай байгууллагад ирж ажиллахыг санал болгоно. | 18.2 | 24.8 | 36.4 | 20.6 | **3** | 12.4 | 24.5 | 36.3 | 26.7 | **3** |
| 3.10 | Би ажилдаа сэтгэл ханамжтай байдаг. | 7.8 | 20.7 | 44.4 | 27.1 | **3** | 3.7 | 16.8 | 41.6 | 37.9 | **3** |
| *Ажлын гүйцэтгэл болон мэргэжлийн ур чадвартай холбоотой сэтгэл ханамж* | | | | | | | | | | | |
| 3.11 | Би өөрийн ажлын гүйцэтгэлдээ сэтгэл хангалуун байдаг. | 2.5 | 11.4 | 47.0 | 39.1 | **3** | - | - | - | - | **-** |
| 3.12 | Багшийн ажлын гүйцэтгэлийн хөндлөнгийн үнэлгээнд сэтгэл хангалуун байдаг. | 13.1 | 35.4 | 38.6 | 12.9 | **3** | - | - | - | - | **-** |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.13 | Би мэргэжлийн мэдлэг, ур чадвартаа сэтгэл хангалуун байдаг. | 4.2 | 12.8 | 46.1 | 36.9 | **3** | - | - | - | - | - |
| 3.14 | Би мэдээллийн технологийн чадвартаа сэтгэл хангалуун байдаг. | 4.3 | 18.8 | 48.9 | 28.0 | **3** | - | - | - | - | - |

*Тэмдэглэл.* Огт санал нийлэхгүй байна. - 1; Санал нийлэхгүй байна. - 2; Санал нийлж байна. - 3; Бүрэн санал нийлж байна. – 4

Цалин хөлс болон ажлын орчинтой холбоотой сэтгэл ханамжийн үр дүнгийн тухайд (Хүснэгт 8 ба 9) бүх шатны сургалтын байгууллагын багш нар ихэнх нь одоо авч буй цалин хөлсөндөө сэтгэл ханамжгүй (*Mo=1* буюу "огт санал нийлэхгүй байна") гэжээ. Ажлын орчин нөхцөлийн хувьд СӨБ, ЕБ болон ДБ-ын сургалтын байгууллагын багш нар сэтгэл хангалуун байна (*Mo=3*). Багш нарт төрөөс орон сууцны нөхцөлөө сайжруулах болон тэдний эрүүл мэндэд анхаарч дэмжлэг үзүүлдэггүй гэж бүх түвшний сургалтын байгууллагын багш нар дүгнэжээ (*Mo=1* болон *Mo=2*). Гэхдээ ДБ-ын сургалтын байгууллагын багш нараас авсан асуулгад тухайн багшийн ажиллаж буй сургалтын байгууллагаас орон сууцны дэмжлэг үзүүлдэг эсэх дээр хариулт авсныг энд тэмдэглэх нь зүйтэй. "Боловсролын бодлого боловсруулахад багш нарын санал бодлыг тусгадаг" эсэхэд бүх түвшний багш нарын ихэнх нь "огт санал нийлэхгүй" болон "санал нийлэхгүй" байна (*Mo=1* ба *Mo=2*).

*Хүснэгт 8. Цэцэрлэг болон ЕБС-ийн багшийн цалин хөлс болон ажлын орчин нөхцөлтэй холбоотой сэтгэл ханамж, хувиар*

| № | Цалин хөлс болон ажлын орчин нөхцөлтэй холбоотой сэтгэл ханамж | Цэцэрлэгийн багш (*n=1091*) | | | | | ЕБС-ийн багш (*n=7242*) | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1 (%) | 2 (%) | 3 (%) | 4 (%) | *Моод (Мо)* | 1 (%) | 2 (%) | 3 (%) | 4 (%) | *Моод (Мо)* |
| 4.1 | Би цалиндаа сэтгэл хангалуун байдаг. | 46.2 | 32.5 | 15.4 | 5.9 | **1** | 59.2 | 29.0 | 9.1 | 2.7 | **1** |
| 4.2 | Би нэмэгдэл цалин хөлсдөө сэтгэл хангалуун байдаг. | 38.7 | 32.2 | 22.0 | 7.1 | **1** | 46.4 | 33.2 | 16.6 | 3.7 | **1** |
| 4.3 | Ажлын орчин нөхцөлдөө сэтгэл хангалуун байдаг. | 14.4 | 22.4 | 37.3 | 25.9 | **3** | 20.6 | 29.7 | 37.3 | 12.4 | **3** |
| 4.4 | Багш нарт орон байрны нөхцөлийг сайжруулахад төрөөс дэмжлэг үзүүлдэг. | 74.8 | 14.9 | 6.4 | 3.8 | **1** | 66.8 | 22.3 | 7.7 | 3.1 | **2** |
| 4.5 | Багш нарын эрүүл мэндэд төрөөс анхаарч дэмжлэг үзүүлдэг. | 46.3 | 29.8 | 17.1 | 6.8 | **1** | 37.4 | 38.0 | 20.9 | 3.7 | **2** |
| 4.6 | Боловсролын бодлого боловсруулахад багш | 39.7 | 30.1 | 24.3 | 6.0 | **1** | 39.8 | 40.0 | 17.1 | 3.1 | **1** |

https://journal.mnier.mn/
ISSN 2959-9164
DOI: https://doi.org/10.56380/v28.2.3

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нарын санал бодлыг тусгадаг. | | | | | | | | | | |

*Тэмдэглэл.* Огт санал нийлэхгүй байна. - 1; Санал нийлэхгүй байна. - 2; Санал нийлж байна. - 3; Бүрэн санал нийлж байна. – 4

*Хүснэгт 9. МБТБ болон ДБ-ын сургалтын байгууллагын багшийн цалин хөлс болон ажлын орчин нөхцөлтэй холбоотой сэтгэл ханамж, хувиар*

| **№** | **Цалин хөлс болон ажлын орчин нөхцөлтэй холбоотой сэтгэл ханамж** | **МБТБ-ын сургалтын байгууллагын багш (*n=947*)** | | | | | **ДБ-ын сургалтын байгууллагын багш (*n=1149*)** | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1 *(%)* | 2 *(%)* | 3 *(%)* | 4 *(%)* | *Моод (Мо)* | 1 *(%)* | 2 *(%)* | 3 *(%)* | 4 *(%)* | *Моод (Мо)* |
| 4.1 | Би цалиндаа сэтгэл хангалуун байдаг. | 65.5 | 25.4 | 7.5 | 1.6 | **1** | 44.1 | 32.6 | 18.7 | 4.5 | **1** |
| 4.2 | Би нэмэгдэл цалин хөлсдөө сэтгэл хангалуун байдаг. | 51.1 | 33.1 | 13.7 | 2.1 | **1** | 44.6 | 32.0 | 18.2 | 5.2 | **1** |
| 4.3 | Ажлын орчин нөхцөлдөө сэтгэл хангалуун байдаг./ Ажлын байрны хангамж, ажиллах орчинд сэтгэл хангалуун байна[а]. | 31.5 | 38.6 | 25.7 | 4.2 | **2** | 22.3 | 30.9 | 33.6 | 13.2 | **3** |
| 4.4 | Багш нарт орон байрны нөхцөлийг сайжруулахад төрөөс дэмжлэг үзүүлдэг. / Сургуулиас орон байрны нөхцөлөө сайжруулахад дэмжлэг үзүүлдэг[в]. | 74.8 | 17.7 | 5.7 | 1.8 | **1** | 59.4 | 21.2 | 13.7 | 5.7 | **1** |
| 4.5 | Багш нарын эрүүл мэндэд төрөөс анхаарч дэмжлэг үзүүлдэг. | 53.2 | 32.6 | 11.9 | 2.2 | **1** | 44.8 | 33.9 | 17.1 | 4.2 | **1** |
| 4.6 | Боловсролын бодлого боловсруулахад багш нарын санал бодлыг тусгадаг. | 45.1 | 37.0 | 15.4 | 2.5 | **1** | 36.6 | 40.1 | 19.8 | 3.5 | **2** |

*Тэмдэглэл.* Огт санал нийлэхгүй байна- 1; Санал нийлэхгүй байна- 2; Санал нийлж байна- 3; Бүрэн санал нийлж байна- 4
[а] – МБТБ-ын сургалтын байгууллагын багшийн асуулга
[в] – ДБ-ын сургалтын байгууллагын багшийн асуулга

СӨБ, ЕБ, МБТБ-ын сургалтын байгууллагын багш нар ажиллаж буй байгууллага болон хамт олондоо сэтгэл хангалуун (*Мо=3*) байна (Хүснэгт 10). Харин МБТБ-ын сургалтын байгууллагын багш нарын тухайд мэргэжил дээшлүүлэх сургалт, үйл ажиллагааны чанар, хүртээмжид сэтгэл хангалуун бус байна гэсэн хариулт илүү давтамжтай байна.

*Хүснэгт 10. Цэцэрлэг, ЕБС болон МБТБ-ын сургалтын байгууллага, хамт олонтой холбоотой сэтгэл ханамж, хувиар*

| № | Сургалтын байгууллагатай холбоотой сэтгэл ханамж | Цэцэрлэгийн багш (*n=1091*) | | | | | ЕБС-ийн багш (*n=7242*) | | | | | МБТБ-ын сургалтын байгууллагын багш (*n=947*) | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1 (%) | 2 (%) | 3 (%) | 4 (%) | *Моод (Мо)* | 1 (%) | 2 (%) | 3 (%) | 4 (%) | *Моод (Мо)* | 1 (%) | 2 (%) | 3 (%) | 4 (%) | *Моод (Мо)* |
| 5.1 | Манай байгууллага хамтын (удирдлага, багш, ажилтан) хариуцлага хүлээх соёлтой. | 8.0 | 19.1 | 37.4 | 35.6 | **3** | 9.2 | 24.6 | 47.3 | 18.9 | **3** | 14.3 | 32.6 | 39.6 | 13.5 | **3** |
| 5.2 | Манай байгууллагын хамт олон хамтран ажиллах соёлыг хэвшүүлсэн. | 4.8 | 13.4 | 43.0 | 38.9 | **3** | 5.9 | 22.8 | 51.1 | 20.3 | **3** | 10.0 | 27.9 | 46.7 | 15.4 | **3** |
| 5.3 | Манай байгууллага шинэ санал, санаачилга гаргасан багш, ажилтныг дэмждэг. | 8.4 | 18.6 | 39.2 | 33.7 | **3** | 7.2 | 23.5 | 48.1 | 21.3 | **3** | 12.4 | 19.6 | 43.0 | 15.1 | **3** |
| 5.4 | Байгууллагын удирдлага багшаа дэмжиж ажилладаг. | 8.4 | 17.0 | 38.3 | 36.3 | **3** | 6.9 | 22.4 | 48.5 | 22.3 | **3** | 13.7 | 32.2 | 40.0 | 14.0 | **3** |
| 5.5 | Манай байгууллагын удирдлага, хамт олны харилцаа, хандлага таатай. | 7.5 | 16.0 | 38.7 | 37.8 | **3** | 6.8 | 23.3 | 47.9 | 22.0 | **3** | 13.0 | 30.8 | 41.0 | 15.2 | **3** |
| 5.6 | Байгууллагын удирдлагын зүгээс шагнал, урамшуулал, нэмэгдэл хөлсийг шударгаар олгодог. | 11.3 | 21.6 | 35.7 | 31.4 | **3** | 8.5 | 24.0 | 45.0 | 22.5 | **3** | 20.4 | 31.5 | 34.8 | 13.3 | **3** |
| 5.7 | Миний ажиллаж буй байгууллагын газар зүйн байршил надад таалагддаг. | 6.2 | 11.1 | 35.8 | 46.8 | **3** | 6.0 | 16.2 | 45.8 | 32.0 | **3** | 7.3 | 15.0 | 42.2 | 35.5 | **3** |
| 5.8 | Би ажлаас халагдах айдасгүй ажилладаг. | 9.1 | 12.2 | 30.7 | 48.0 | **3** | 7.0 | 15.0 | 42.4 | 35.5 | **3** | 10.5 | 21.3 | 41.2 | 27.0 | **3** |
| 5.9 | Байгууллага дахь хөдөлмөрийн болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд сэтгэл хангалуун байдаг. | 8.9 | 16.4 | 42.1 | 32.6 | **3** | 7.0 | 25.3 | 49.2 | 18.6 | **3** | 13% | 32.4 | 42.2 | 12.4 | **3** |
| 5.10 | Мэргэжил дээшлүүлэх сургалт, үйл ажиллагааны чанар, хүртээмжид би сэтгэл хангалуун байдаг. | 5.4 | 15.2 | 44.1 | 35.3 | **3** | 7.9 | 25.8 | 48.5 | 17.9 | **3** | 19.1 | 36.7 | 34.0 | 10.1 | **2** |

https://journal.mnier.mn/
ISSN 2959-9164
DOI: https://doi.org/10.56380/v28.2.3

*Тэмдэглэл.* Огт санал нийлэхгүй байна. - 1; Санал нийлэхгүй байна. - 2; Санал нийлж байна. - 3; Бүрэн санал нийлж байна. – 4
*Тайлбар.* ДБ-ын сургалтын байгууллагын багшийн асуулгад 5.9 дэх асуултаас бусад асуулт ороогүй тул дээрх хүснэгтэд мэдээлэл ороогүй болно.

*Крускал-Уоллис тестийн үр дүн*

Крускал-Уоллис тест ашиглан СӨБ, ЕБ, МБТБ болон дээд боловсролын сургалтын байгууллагын багш нарын дунд статистик ач холбогдол бүхий ялгаа байгаа эсэхэд шинжилгээ хийсэн үр дүнг Хүснэгт 11-д харуулав. Дараах таамаглалыг судалгааны зорилгын хүрээнд дэвшүүлсэн. Үүнд:

- $H_0$ СӨБ, ЕБ, МБТБ болон ДБ-ын сургалтын байгууллагын багш нарын хооронд ажлын сэтгэл ханамжийн ялгаа байхгүй.
- $H_1$ СӨБ, ЕБ, МБТБ болон ДБ-ын сургалтын байгууллагын багш нарын хооронд ажлын сэтгэл ханамж ялгаатай.

Крускал-Уоллис тестийн үр дүнгээс үзвэл бүх $\rho$ утга 0.001-ээс бага буюу статистик ач холбогдол өндөр байгааг харуулж байна. Иймд 0 таамаглалын хүлээн зөвшөөрөхгүй бөгөөд СӨБ, ЕБ, МБТБ болон дээд боловсролын сургалтын байгууллагын багш нарын хооронд ажлын сэтгэл ханамж ялгаатай байна.

*Хүснэгт 11. Крускал-Уоллис тестийн үр дүн /бүх түвшний сургалтын байгууллагын багш нарын хооронд/, хувиар*

| | № | Айтемс | Kruskal-Wallis H | df | Asymp. Sig. |
|---|---|---|---|---|---|
| Ажлын стресс | 1.1 | Би ажилдаа стрессддэг | 54.470 | 3 | 0.000 |
| | 1.2 | Миний ажил надад хувийн амьдралдаа цаг зарцуулах боломж олгодоггүй | 76.787 | 3 | 0.000 |
| | 1.3 | Миний ажил сэтгэл зүйд минь сөргөөр нөлөөлдөг | 93.559 | 3 | 0.000 |
| | 1.4 | Миний ажил эрүүл мэндэд (биеийн) минь сөргөөр нөлөөлдөг | 147.653 | 3 | 0.000 |
| Стрессийн шалтгаан, эх үүсвэр | 2.1 | Хичээлийн бэлтгэлд цаг их зарцуулдаг нь намайг бухимдуулдаг | 34.380 | 2 | 0.000 |
| | 2.2 | Долоо хоногт заах хичээлийн цаг их байдаг нь намайг бухимдуулдаг | 81.933 | 2 | 0.000 |
| | 2.4 | Байгууллагын захиргааны ажил (маягт бөглөх, бичиг цаасны ажил гм) - д их оролцох нь надад төвөгтэй байдаг | 33.381 | 3 | 0.000 |
| | 2.5 | Эзгүй байгаа багшийн ажлыг давхар гүйцэтгэх нь надад хүндрэлтэй байдаг | 37.741 | 3 | 0.000 |
| | 2.6 | Суралцагчийн сурлагын ахиц, амжилтад хариуцлага хүлээх нь надад хэцүү санагддаг | 233.881 | 2 | 0.000 |
| | 2.7 | Суралцагчдын зүй бус харилцаа намайг бухимдуулдаг | 293.059 | 2 | 0.000 |
| | 2.8 | Ялгаатай хэрэгцээ шаардлагатай суралцагчдад зориулж багшлах үйл ажиллагаандаа тохируулга хийх нь хүндрэл учруулдаг | 103.600 | 3 | 0.000 |
| | 2.9 | Эцэг эх, асран хамгаалагчийн харилцаа, хандлага стрессдүүлдэг | 196.314 | 2 | 0.000 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 2.10 | Дээд шатны байгууллага бодлого, шийдвэрээ богино хугацаанд өөрчилдөг нь намайг бухимдуулдаг | 73.171 | 3 | 0.000 |
| Ажлынбайрны дарамттай холбоотой | 2.11 | Байгууллагын удирдлагын зүгээс ажлын байрны дарамт (сэтгэл зүйн болон биеийн) үзүүлдэг | 109.956 | 3 | 0.000 |
| | 2.12 | Хамт олны зүгээс ажлын байрны дарамт (сэтгэл зүйн болон биеийн) үзүүлдэг | 83.374 | 3 | 0.000 |
| | 2.13 | Удирдлагын тогтворгүй байдал нь миний ажилд хүндрэл учруулдаг | 235.881 | 3 | 0.000 |
| Мэргэжил болон ажлын сэтгэл ханамж | 3.1 | Багш мэргэжил давуу тал ихтэй гэж би боддог | 256.177 | 3 | 0.000 |
| | 3.2 | Хэрэв мэргэжил дахин сонгох болбол би багш мэргэжлийг сонгоно | 31.460 | 2 | 0.000 |
| | 3.3 | Би багш мэргэжлийг сонгосондоо сэтгэл дундуур байдаг | 97.575 | 2 | 0.000 |
| | 3.4 | Би өөр мэргэжил сонгосон бол илүү сэтгэл хангалуун байх байсан | 90.216 | 2 | 0.000 |
| | 3.5 | Миний бодлоор багшийн ажил нь нийгэмд нэр хүндтэй | 379.050 | 3 | 0.000 |
| | 3.6 | Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл нь багшийн нэр хүндийг өсгөхөд нөлөөлдөг | 24.911 | 3 | 0.000 |
| | 3.7 | Би боломж олдвол өөр сургалтын байгууллага руу шилжин ажиллах хүсэлтэй | 54.723 | 3 | 0.000 |
| | 3.8 | Би энэ байгууллагад ажиллахдаа дуртай байдаг | 88.449 | 3 | 0.000 |
| | 3.9 | Би багш нарт манай байгууллагад ирж ажиллахыг санал болгоно | 30.683 | 3 | 0.000 |
| | 3.10 | Би ажилдаа сэтгэл ханамжтай байдаг | 165.541 | 3 | 0.000 |
| Ажлын гүйцэтгэл болон ур чадвартай холбоотой | 3.1 | Би өөрийн ажлын гүйцэтгэлдээ сэтгэл хангалуун байдаг | 99.199 | 2 | 0.000 |
| | 3.1 | Багшийн ажлын гүйцэтгэлийн хөндлөнгийн үнэлгээнд сэтгэл хангалуун байдаг | 270.805 | 2 | 0.000 |
| | 3.1 | Би мэргэжлийн мэдлэг, ур чадвартаа сэтгэл хангалуун байдаг | 55.780 | 2 | 0.000 |
| | 3.1 | Би мэдээллийн технологийн чадвартаа сэтгэл хангалуун байдаг | 70.670 | 2 | 0.000 |
| Цалин хөлс, нийгмийн баталгаатай холбоотой сэтгэл ханамж | 4.1 | Би цалиндаа сэтгэл хангалуун байдаг | 218.420 | 3 | 0.000 |
| | 4.2 | Би нэмэгдэл цалин хөлсдөө сэтгэл хангалуун байдаг | 61.781 | 3 | 0.000 |
| | 4.3 | Ажлын орчин нөхцөлдөө сэтгэл хангалуун байдаг | 284.684 | 3 | 0.000 |
| | 4.4 | Багш нарт орон байрны нөхцөлийг сайжруулахад төрөөс дэмжлэг үзүүлдэг | 94.891 | 3 | 0.000 |
| | 4.5 | Багш нарын эрүүл мэндэд төрөөс анхаарч дэмжлэг үзүүлдэг | 108.767 | 3 | 0.000 |
| | 4.6 | Боловсролын бодлого боловсруулахад багш нарын санал бодлыг тусгадаг | 31.724 | 3 | 0.000 |
| Сургалтын байгууллага, хамт олонтой холбоотой | 5.1 | Манай байгууллага хамтын (удирдлага, багш, ажилтан) хариуцлага хүлээх соёлтой | 162.807 | 2 | 0.000 |
| | 5.2 | Манай байгууллагын хамт олон хамтран ажиллах соёлыг хэвшүүлсэн | 208.400 | 2 | 0.000 |
| | 5.3 | Манай байгууллага шинэ санал, санаачилга гаргасан багш, ажилтныг дэмждэг | 104.024 | 2 | 0.000 |
| | 5.4 | Байгууллагын удирдлага багшаа дэмжиж ажилладаг | 173.764 | 2 | 0.000 |

https://journal.mnier.mn/
ISSN 2959-9164
DOI: https://doi.org/10.56380/v28.2.3

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 5.5 | Манай байгууллагын удирдлага, хамт олны харилцаа, хандлага таатай | 170.719 | 2 | 0.000 |
| | 5.6 | Байгууллагын удирдлагын зүгээс шагнал, урамшуулал, нэмэгдэл хөлсийг шударгаар олгодог | 167.345 | 2 | 0.000 |
| | 5.7 | Миний ажиллаж буй байгууллагын газар зүйн байршил надад таалагддаг | 68.971 | 2 | 0.000 |
| | 5.8 | Би ажлаас халагдах айдасгүй ажилладаг | 87.190 | 2 | 0.000 |
| | 5.9 | Байгууллага дахь хөдөлмөрийн болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд сэтгэл хангалуун байдаг | 620.739 | 3 | 0.000 |
| | 5.10 | Мэргэжил дээшлүүлэх сургалт, үйл ажиллагааны чанар, хүртээмжид би сэтгэл хангалуун байдаг | 377.790 | 2 | 0.000 |

## ДҮГНЭЛТ

- Бүх шатны сургалтын байгууллагын багш нарын хувьд өөрийн ажлын гүйцэтгэл, мэргэжлийн ур чадвар, ажил болон сургалтын байгууллага, хамт олон, мэргэжил дээшлүүлэх сургалтын чанар, хүртээмжид сэтгэл хангалуун байна. Харин бүх түвшний сургалтын байгууллагын багш нар цалин хөлс болон нийгмийн баталгаатай холбоотой зүйлсэд сэтгэл хангалуун бус байгаагаа илэрхийлжээ. Үүнээс гадна СӨБ, ЕБ, МБТБ-ын сургалтын байгууллагын багш нарын тал хувь нь хэрэв мэргэжлээ дахин сонгох бол өөр мэргэжил сонгох байсан гэж хариулсан нь анхаарал татаж байна.
- Судалгаанд оролцогчид тодорхой хэмжээгээр ажилдаа стрессддэг болохоо илэрхийлсэн бөгөөд талаас илүү хувь нь байгууллагын захиргааны ажил болон дээд шатны байгууллагын бодлого, шийдвэр богино хугацаанд өөрчлөгддөг байдал нь тэднийг илүү бухимдуулдаг болохыг судалгаа харууллаа.
- Бүх түвшний сургалтын байгууллагын багшийн ажлын сэтгэл ханамж нь статистик өндөр ач холбогдол бүхий ялгаатай байна ($\rho$ <0.001). Иймд багшийн ажлын сэтгэл ханамжийг дээшлүүлэхийн тулд тухайн шатны сургалтын байгууллагын нийтлэг асуудлаас гадна онцлог асуудлуудад төвлөрч шийдвэрлэх нь чухал юм.
- Энэхүү судалгааны үр дүн нь салбарын хүний нөөцийн хөгжлийн бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааг төлөвлөх, сайжруулахад хувь нэмэр оруулах боломжтойгоороо практик ач холбогдолтой.

## НОМ ЗҮЙ

*Монгол хэлээр:*

БХ. (2019). *Монгол Улсын Боловсролын суурь мэдээллийн тайлан.* Улаанбаатар: Гоо дизайн ХХК.

БШУС. (2021). *"Хөтөлбөр, төлөвлөгөө батлаж, хэрэгжилтийг хангах тухай" 91 дүгээр тушаал.*

Г.Өлзийсайхан. (2017). ЕБС-ийн багшийн ажлын сэтгэл ханамжийн судалгаа. *Эрдэм Шинжилгээний Бичиг, 19*, 18-24.

Д.Түмэнбаяр, А. Ц.-А. (2021). Багшийн ажлын байран дахь сэтгэл ханамжийн судалгаа. *ISE-2021_PROCEEDINGS-online*, (хуудас. 21-29). https://sas.num.edu.mn/mn/wp-content/uploads/2021/04/ISE-2021_PROCEEDINGS-online-1-251-cover-22-30.pdf-ээс гаргасан

УИХ. (2018). *Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль.* Улаанбаатар

*Гадаад хэлээр:*

Akiba, M. (2007). *Teacher Reforms Around the World: Implementations and Outcomes.* Emerald Publishing Limited.

Akiba, M., & LeTendre, G. K. (2017). *International Handbook of Teacher Quality and Policy.* New York: Routledge.

Forde, C., & McMahon, M. (2019). *Teacher Quality, Professional Learning and Policy: Recognising, Rewarding and Developing Teacher Expertise.* Palgrave Macmillan UK.

Hasanzadeh, E., & Gholami, J. (2023). Possible Relationship among Experience, Age, Income Level, Gender, and Job Satisfaction. *Journal of English Language Pedagogy, Literature and Culture, 8*, 35-46.

Noe, R. A., Hollenbeck, J. R., Gerhart, B., & Wright, P. M. (1996). *Human Resource Managment: Gaining a Competetive Advantage* (Second edition хян.). USA: McGraw-Hill.

OECD. (2009). *TALIS 2009 Results: Creating Effective Teaching and Learning Environments: First Results from TALIS.* OECD Publishing.

Özkan, U. B., & Akgenç, E. (2023). Teachers' Job Satisfaction: Multilevel Analysis of Teacher, School, and Principal effects. *Forum for International Research in Education, 7*, 1-23.

UNESCO. (2019). *Teacher Policy Development Guide.* UNESCO.

## ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааны ажлын мэдээлэл цуглуулахад туслалцаа үзүүлсэн БШУЯ-ны Цахим бодлого, статистик мэдээллийн газар болон Боловсролын мэдээллийн технологийн төв, судалгааны мэдээллийг боловсруулахад дэмжлэг үзүүлсэн Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн (БСҮХ)-ийн Өгөдөл боловсруулалт, цахим судалгааны секторын хамт олон, судалгааны асуулгыг сайжруулахад санал өгсөн БСҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан Ж.Энхтүвшин, Г.Баярмөнх, Б.Энхбаяр нарт талархсанаа илэрхийлье.